

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОО-2024/02/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Аудитор: С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	9
4. Аудитын тайлан.....	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. Аудитын илрүүлэлт	13
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	13

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨА	Төрийн өмчит аж ахуйн

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.03.19 № 299

танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ “ЧОЙБАЛСАН”
НИСЭХ БУУДЛЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.АЛТАНТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн, нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

011021141

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	12,062,912.38	455,149.94
1.1.2	Дансны авлага	-	7,637,554.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	13,540.00	-
1.1.4	Бусад авлага	4,631,860.00	-
1.1.6	Бараа материал	182,243,480.36	199,797,459.44
1.1.7	Урьдчилж төлсөн зардал	-	4,290,625.74
	Эргэлтийн хөрөнгийн дүн	198,951,792.74	212,180,789.11
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,707,433,459.77	3,055,282,547.18
1.2.2	Биет бус хөрөнгө	203,027,422,942.37	203,014,628,384.03
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	5,294,929.95	4,527,211.47
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	206,740,151,332.09	206,074,438,142.68
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	206,939,103,124.83	206,286,618,931.79
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	-	-
2.1.	Өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	79,721.14	-
2.1.1.3	Татварын өр	-	6,233,202.45
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	718,360
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	79,721.14	6,951,562.45
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	79,721.14	6,951,562.45
2.3	Эздийн өмч	205,493,315,995.40	205,075,694,212.52
2.3.1	Өмч: - төрийн	203,000,000,000.00	203,000,000,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,493,315,995.40	2,075,694,212.52
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,445,707,408.29	1,203,973,156.82
	Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг	1,445,707,408.29	1,863,329,191.17
	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(659,356,034.35)
	Эздийн өмчийн дүн	206,939,023,403.69	206,279,667,369.34
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	206,939,103,124.83	206,286,618,931.79

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.1	Борлуулалтын орлого (Цэвэр)	1,842,889.20	20,314,676.83
1.2	Борлуулалтын өртөг	1,420,714,329.03	1,914,106,483.67
1.3	Нийт ашиг (алдагдал)	(1,418,871,439.83)	(1,893,791,806.84)
1.4	Үйл ажиллагаа (Борлуулалт, ерөнхий удирдлага)-ны зардал	900,000.00	900,000.00
	Аудит баталгаажуулалтын зардал	900,000.00	900,000.00
1.5	Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(1,419,771,439.83)	(1,894,691,806.84)
2	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	1,565,767,425.57	1,235,335,772.49
2.1	Бусад үйл ажиллагааны бус орлого	1,611,657,187.24	1,279,314,095.98
	Хүүгийн орлого	-	266,122.91
	Санхүүжилтийн орлого	1,203,041,860.46	901,545,700.00
	Систем хоорондын тооцоогоорх орлого	401,114,055.76	352,637,078.91
	Үйл ажиллагааны бусад орлого	-	24,865,194.16
	Үндсэн хөрөнгийн дотоод хөдлөлийн борлуулалтын олз	7,501,271.02	-
2.2	Бусад үйл ажиллагааны бус зардал	45,889,761.67	43,978,323.49
2.3	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)-ын дүн	1,565,767,425.57	1,235,335,772.49
3	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	145,995,985.74	(659,356,034.35)
	Орлогын татварын зардал	-	-
4	Татварын дараах ашиг (алдагдал)	145,995,985.74	(659,356,034.35)
	Цөөнхөд ноогдох хувь	-	-
5	Ердийн ажиллагааны ашиг (алдагдал)	145,995,985.74	(659,356,034.35)
	Онцгой шинжтэй зүйлс - цэвэр	-	-
6	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	145,995,985.74	(659,356,034.35)
	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудлын 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	203,000,000,000.00	2,493,315,995.40	1,445,707,408.29	206,939,023,403.69
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	203,000,000,000.00	2,493,315,995.40	1,445,707,408.29	206,939,023,403.69
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-
9	2022 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	203,000,000,000.00	2,493,315,995.40	1,445,707,408.29	206,939,023,403.69
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	203,000,000,000.00	2,493,315,995.40	1,445,707,408.29	206,939,023,403.69
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(659,356,034.35)	(659,356,034.35)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гаргасан өөрчлөлт	-	(417,621,782.88)	(417,621,782.88)	-
17	2023 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	203,000,000,000.00	2,075,694,212.52	1,203,973,156.82	206,279,667,369.34

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,205,745,912.52	926,410,894.16
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,192,590,000.00	901,545,700.00
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	13,155,912.52	24,865,194.16
1.1.6.1	Банк хоорондын гүйлгээ	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,214,496,629.70	938,284,779.51
1.2.1	Ажиллагчдад төлсөн	657,359,729.36	557,865,628.90
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	196,921,391.99	109,419,706.55
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	109,334,763.00	80,949,993.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	68,052,129.83	48,201,096.34
1.2.5	Хүүний төлбөрт төлсөн	-	26,612.29
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	58,423,930.00	59,131,040.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	84,777,428.52	47,560,788.54

Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудлын 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	10,810,585.00	7,654,383.39
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	28,816,672.00	27,475,530.50
1.2.9.1	Банк хоорондын гүйлгээ	-	-
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(8,750,717.18)	(11,873,885.35)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	266,122.91
	Хүлээн авсан хүүний орлого	-	266,122.91
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(8,750,717.18)	(11,607,762.44)
4	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(8,750,717.18)	(11,607,762.44)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,813,629.56	12,062,912.38
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,062,912.38	455,149.94

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны			
		төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ МӨНГӨН ДҮН	1,622,250,793.62	1,522,905,200.00	1,311,691,685.19	211,213,514.81	86.1
Мөнгөн хөрөнгийн 2023.01.01 -ний эхний үлдэгдэл	20,813,629.56	12,062,913.38	12,062,913.38	0.0	100.0
Нийт орлого	1,601,437,164.06	1,510,842,287.62	1,299,628,772.81	211,213,514.81	86.0
Борлуулалтын орлого	1,842,889.20	4,500,000.00	20,314,676.83	-15,814,676.83	451.4
Татаас санхүүжилтийн орлого	1,611,657,187.24	1,518,405,200.00	1,279,047,973.07	239,357,226.93	84.2
Бусад орлого			266,122.91	-266,122.91	
Нийт зарлага	1,420,714,329.03	2,172,156,822.71	1,914,106,483.67	258,050,339.04	88.1
Борлуулалтын бүтээгдэхүүний өртөг	1,420,714,329.03	2,184,219,735.09	1,914,106,483.67	270,113,251.42	87.6
Нийт ашиг алдагдал	12,062,912.38	-661,314,535.09	-659,356,034.35		
Орлогын албан татварын зардал	0.0	0.0	0.0		
Ажиллагсдын тоо	38	38	33	5.0	
Нийт цалингийн сан	692,080,379.26	998,823,900.00	835,262,335.61	163,561,564.39	83.6
Нийт авлага	4,645,400.00	0.0	7,637,554.00		
Нийт өглөг	79,721.14	0.0	6,951,562.45		
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ 2023.12.31	12,062,912.38	0.0	455,149.94		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудал нь агаарын зайд эдийн засгийн үр ашигтай агаарын навигацийн үйлчилгээ, нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх, удирдан чиглүүлэх, зохион байгуулалтаар хангах үйл ажиллагаа явуулдаг, Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа байгууллага юм.

Үйл ажиллагааны эрхэм зорилго нь иргэний нисэхийн салбарт аюулгүй, үр ашигтай, тогтвортой үйлчилгээ үзүүлэхэд оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудал нь Иргэний нисэхийн тухай хууль, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд онцлох өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн Сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 652.5 сая төгрөгөөр буюу 0.3%-иар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12,062.9	455.1	-11,607.8
Авлага	4,645.4	7,637.6	2,992.2
Урьдчилж төлсөн зардал	0.0	4,290.6	4,290.6
Бараа материал	182,243.5	199,797.5	17,554.0
Үндсэн хөрөнгө	206,740,151.3	206,074,438.1	-665,713.2
Нийт хөрөнгө	206,939,103.1	206,286,618.9	-652,484.2
Өр төлбөр	79.7	6,951.5	6,871.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	206,939,023.4	206,279,667.4	-659,356.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	206,939,103.1	206,286,618.9	-652,484.2

Дээрх хүснэгтээс харахад бараа материалын дансны үлдэгдэл 199.8 сая төгрөг болж 17.5 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан бараа материалын зарцуулалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 206,074.4 сая төгрөг болж 665.7 сая төгрөгөөр буурсан нь элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан, ашиглаж байгаа хөрөнгүүдэд холбогдох шийдвэрээр үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосон, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнг хорогдуулсантай холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу төрийн өмчит үйлдвэрийн газар нь тухайн оны санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж биелэлтийг хангах үүрэгтэй.

Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудлын 2023 оны орлого, зардлын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны үндсэн үйл ажиллагааны орлогыг 4.5 сая төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,505.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,509.8 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Гүйцэтгэлээр 901.5 сая төгрөгийн татаас санхүүжилт, 321,5 сая төгрөгийн орлогыг системийн хоорондын тооцоогоор тус тус авч, үндсэн үйл ажиллагаанаас 20.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,286.6 сая төгрөгийн зардал гарган ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 20.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 16.0 сая төгрөг буюу 400 хувиар давсан нь 2023 онд орон нутгийн тогтмол нислэгтэй болсноос шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 1,286.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 223.2 сая төгрөг буюу 85.2 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь 2023 оны 1-4 сард 19 ажилтан сул зогссон нь гол нөлөө үзүүлсэн байна. Тайлант онд цэвэр алдагдал 659.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 395.5 сая төгрөгөөр илүү байгаа нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг хорогдуулсан нь нөлөөлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Энхбаатар гүйцэтгэж, хяналтыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн зардлын 1,914.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 28.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар болгон өөрчлөөгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.", MNS 4410-1:2002 стандартын 5.4.9-т "Төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дэвсгэр нь хар хөх, тоо, үсэг ба хүрээ нь цагаан өнгөтэй байна" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгч ажиллалаа.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудлын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нэг зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0.0	1	0.0	100
Нийт дүн	1	0.0	1	0.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар болгон хэрэглээгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ", MNS 4410-1:2002 стандартын 5.4.9-т "Төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дэвсгэр нь хар хөх, тоо, үсэг ба хүрээ нь цагаан өнгөтэй байна" гэснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, MNS 4410-1:2002 стандартын 5.4.9-т нийцүүлэн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар болгон өөрчлөх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэж заасан. Харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байна.	1	0					1	0				
Дүн	1	0					1	0				